



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/723

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Ар-Онгот” ХХК-ний хийж гүйцэтгэсэн Жаргалант сумын 48 айлын орон сууцны дотор шугам шинэчлэх ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Дөлбадрал -Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга

Гишүүд:

Ш.Мөнхзаяа - Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын Улсын байцаагч

Р.Янжмаа - Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн

Д.Эрдэнэбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэд бүтэц хариуцсан гэрээт ажилтан

Г.Тунгалаг - Жаргалант сумын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн


Ц.Даваасамбуу -Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн
С.Батдорж -Аймгийн архивын тасгийн дарга
Б.Цэвээндорж - “Ар-Онгот”ХХК-ний захирал
Г.Цэдэнбал -Монгол улсын Гавъяат барилгачин

Нарийн бичгийн
дарга:

С.Өнөржаргал -Газрын харилцаа барилга хот байгуулалтын
газрын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

2. “Ар-Онгот” ХХК-ний хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Э.Дөлбадрал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН